



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/174

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай  
зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, 19.10, 19.18, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3 дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар сунгасугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа)-д, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190471

Аймгийн Засаг даргын 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн А/174 дугаар захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН  
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	Орон нутгийн өмчит ААТҮГ	Өндөршил ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/980	5 жил	2019-04-25 2024-04-25
2	Орон нутгийн өмчит ААТҮГ	Адаацаг ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/986	5 жил	2019-04-25 2024-04-25
3	Орон нутгийн өмчит ААТҮГ	Баянжаргалан ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/983	5 жил	2019-04-25 2024-04-25
4	Орон нутгийн өмчит ААТҮГ	Өлзийт ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/984	5 жил	2019-04-25 2024-04-25
5	Орон нутгийн өмчит ААТҮГ	Дэлгэрхангай ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10981	5 жил	2019-04-25 2024-04-25
6	Орон нутгийн өмчит ААТҮГ	Луус ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/982	5 жил	2019-04-25 2024-04-25
7	Орон нутгийн өмчит ААТҮГ	Эрдэнэдалай ЭЭСан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-14/10/985	5 жил	2019-04-25 2024-04-25